



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А119

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Засгийн газрын 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.5, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 03 дугаар тушаалын 02 дугаар хавсралыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан “Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ыг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

М.Анхбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Болд-Эрдэнэ

(Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Түвшинжаргал

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн ажилтан)

Б.Гүнжидмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Б.Ууганболд

(Монтех Дистрибьюшн ХХК-ийн гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Тоног төхөөрөмжийг холбогдох хууль, тогтоомж, техникийн тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, тавигдсан шаардлагын дагуу шалган хүлээн авч, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

